

## Улаанбаатар хотын Цэвэр агаар Нэмэлт Санхүүжилтийн Төсөл

### Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар

Олон нийттэй харилцах, мэдээлэл сурталчилгааны зөвлөх үйлчилгээ

Гэрээний дугаар: AFCA6

#### **Оршил**

Монгол Улсын Засгийн газар нь “Улаанбаатар хотын Цэвэр агаар Нэмэлт Санхүүжилтийн Төсөл”(УБЦА НСТ) (2020 оны 04 дүгээр сард албан ёсоор батлагдсан)-ийг хэрэгжүүлэх зорилгоор Дэлхийн банкнаас хөнгөлөлттэй зээлийг авсан ба зээлийн тодорхой хэсгээр нийслэлийн гэр хорооллын 200,000 гаруй мянган айл өрхүүдэд нэн ялангуяа төвлөрсөн дулаан хангамжинд холбогдоогүй, ихэвчлэн түүхий нүүрс түлж халаалтаа шийддэг өрхүүдэд чиглэсэн олон талт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Гэр хорооллын айл өрхүүдийн хатуу түлшээр галладаг зуух нь Улаанбаатар хотын агаарын бохирдлын 60 гаруй хувийг бүрдүүлж буй гол эх үүсвэр болж байгааг мэргэжлийн байгууллагуудын судалгаагаар тогтоогдсон.

#### **Үндэслэл**

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот нь 1.5 сая гаруй хүн амтай, улсын нийт ДНБ-ний 65%-ийг бүрдүүлдэг бөгөөд УБ хотын агаарын бохирдлын асуудал нь 2008 оноос хойш бүх нийтийн эрүүл мэндэд ноцтой нөлөөлж болохуйц хэмжээнд хүрч аюулын харанга дэлдэж буйг холбогдох эрүүл мэндийн байгууллагууд, олон улсын байгууллагууд анхааруулсаар ирсэн. Нарийн ширхэглэлт тоосонцор нь амьсгалын замаар дамжин хүний эрүүл мэндэд ноцтой аюул учруулж байна. Гэр хорооллын бүсэд амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэд төвлөрөн амьдарч байгаа нь хүрээлэн буй орчин болон нийгмийн шийдэх олон асуудлуудыг араасаа дагуулж байна. 2019 оны 05 дугаар сараас Монгол Улсын Засгийн газар Улаанбаатар хотод түүхий нүүрс оруулж ирэхийг хориглосон 62 дугаар тогтоолыг гаргасан. Уг тогтоол хэрэгжиж иргэд сайжруулсан түлшрүү шилжиж эхэлснээр нийслэлийн агаарын бохирдол 30 хувиар буураад байгааг мэргэжлийн байгууллагууд тодорхойлоод байна. Цаашид Монгол Улсын Засгийн газар УБ хотын агаарын бохирдлыг 80 хүртэлх хувиар бууруулах зорилт тавин ажиллаж байна.

Агаарын бохирдлыг бууруулах төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжих гол үндэс суурь нь олон нийтийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх явдал гэдэг нь дамжиггүй.

УБ хотод агаарын бохирдлын бууруулах төсөл хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд олон нийтэд чиглэсэн кампанит ажлуудыг зөв, хүртээмжтэй тогтмол явуулж, тэдгээрийн эргэх холбоог хангаж ажиллах нь чухал гэдэг дээр Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон хөгжлийн түншүүд санал нэгддэг.

Иймээс Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй УБЦА НСТ-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-д УБ хотын агаарын бохирдлыг бууруулахад олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, тэдгээрийн оролцоог дэмжихэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, удирдах, зохицуулахад мэргэжлийн байгууллагын дэмжлэг, туслалцаа авах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

## **Зорилго**

Энэхүү зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын үндсэн зорилго бол олон нийтийн мэдээлэл сурталчилгааны арга хэмжээний иж бүрэн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, цаашид агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажилладаг иргэд, ТББ болон төслийн оролцогч талуудтай харилцан уялдаатай, тасралтгүй үйл ажиллагааг хамтран явуулахад ТХН-д туслалцаа үзүүлэхэд оршино.

## **Ажлын цар хүрээ:**

Төслийн өмнөх үе шатанд боловсруулсан PR-тай холбоотой баримт бичгүүдийг судлах, шинэчлэх. Үүнд:

1. Нийслэлийн агаарын бохирдлын эсрэг арга хэмжээнд оролцогч талууд (хувийн хэвшил, ТББ, гэр хорооллын иргэд, холбогдох дээд шатны байгууллагууд, албан тушаалтнууд)-ын зураглалыг шинэчлэн гаргаж, дүн шинжилгээ хийх.
2. Олон нийттэй харилцах стратегийг шинэчлэн боловсруулах; (i) нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажилд дэмжлэг үзүүлэх; (ii) НЗДТГ болон агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажиллаж буй оролцогч талуудын арга хэмжээний талаарх эерэг ойлголтыг нийгэмд бий болгох.

Зөвлөх нь УБЦА НСТ-ийн хүрээнд хэрэгжиж байгаа дараах арга хэмжээнүүдэд төвлөрөн ажиллах болно. Үүнд (i) Шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан халаагуур (ШДХЦХ)-ын хөтөлбөрийн тухай, төслийн шалгуур үзүүлэлтийг хангасан эрх бүхий хэрэглэгчтэй байгуулах түрээслээд-өмчлөх гэрээний загвар; (ii) Халаалтын зуухыг буулгах, төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох ажил; (iii) нүүрсний бус халаалтын технологийг нэвтрүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй сууц; (iv) гэр хорооллын айл өрхийн байшин болон гэр сууцны дулаан алдагдлыг бууруулах арга хэмжээ; (v) ТХН-д эрсдэлийг хянах, эрсдлийн менежментийг амжилттай төлөвлөж хэрэгжүүлэх; (vi) Төслийн оролцогч талуудын олон нийтэд чиглэсэн мэдээ, мэдээллийн тогтвортой байдлыг ханган ажиллах (НЗДТГ-н Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс, ЭХЯ, УБЦТС, ОББҮХ).

ТХН, гэр хорооллын айл өрх, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, олон нийт болон төслийн оролцогч талуудын мэдээллийн урсгалын найдвартай, хурдан шуурхай байдлыг хангах. Энэхүү стратеги нь олон нийтэд мэдээллэх мэдээлэл сурталчилгааны зорилгод хэрхэн хүрч ажиллах арга хэлбэр, мессеж, бусад хүчин зүйлсийг агуулсан байх шаардлагатай.

ТХН-тэй хамтран УБЦА НСТ-ийн хүрээнд хэрэгжиж байгаа дээр дурьдсан арга хэмжээнүүд, нэн ялангуяа утаа ялгаруулдаг халаалтын хэрэгслийг “Шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан халаагуур”-аар солих хөтөлбөрийн маркетингийн стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх

Үр дүнтэй богино мэдээ (зурвас)-ыг боловсруулах. Иргэдэд өгөх гол зурвас, санаанууд нь: (a) Айл өрхүүд байшин сууцаа дулаалаад дээр нь эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур ашиглахын давуу талыг ойлгуулах, өөрөөр хэлбэл эдгээрийг хослуулснаас гарах үр дүнг таниулах; (ii) Шөнийн ДХЦХ-ийг худалдан аваад төлбөрөө төлж дууссаны дараа өөрийн өмч болгох “түрээслээд-өмчлөх” загварчлалыг иргэдэд ойлгуулах, уг санхүүгийн схем нь зуухнаас цахилгаан халаагуур руу шилжих хамгийн бага зардлаар үр ашигтай сонголт хийх хувилбар болохыг ойлгуулах; (iii) УБЦА НСТ-ийн хүрээнд боловсруулсан агаарын бохирдлын эсрэг авч хэрэгжүүлэх 4 стандартыг олон нийтэд таниулах, түгээх, эдгээрийг амьдралд хэрэгжүүлэхэд засгийн газрын холбогдох байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх; (iv) агаарын бохирдлыг ямар түвшинд бууруулах, ямар өртгөөр, хэр хурдан хэрэгжиж үр дүнгээ өгөх зэргээс хамаарч юу хийхээ тодорхойлдог байхыг ойлгуулах; (v) гэр хорооллын айл өрхүүдийн амьдран сууж буй орон байраа дулаан алдалгүй болгоход чиглэсэн татаасын механизм хэрэгжүүлж байгааг ойлгуулах. Уг татаасын механизм байнгын үргэлжлэхгүй бөгөөд цаг алдалгүй айл өрхүүд орон байраа дулаалах шаардлагатай ба; (vi) эцэст нь орон байрны дулаалгын хөтөлбөрийг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлэхийн ач холбогдлыг ойлгуулах, сургалтад хамрагдсанаар өөрсдийн орон байраа өөрсдөө дулаалж, тав тухтай, дулаахан орчинд амьдрах боломжийг бүрдүүлэхийг таниулах. Зөвлөх үйлчилгээний баг нь дээрх зурвас, богино мэдээллийг иргэдэд хэрхэн яаж хүргэх стратеги боловсруулж, олон нийтийн мэдээлэл сурталчилгааны ажлын зорилтод хүрэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

Агаарын бохирдол, түүнийг бууруулах төсөл хөтөлбөрүүдийн талаарх гол санаа, мэдлэг, мэдээллийг агуулсан мэдээлэл сурталчилгааны арга хэрэгсэл, бүтээгдэхүүнийг боловсруулж, мэдээлэл сурталчилгааны суваг, платформоор дамжуулан олон нийтэд сурталчлан таниулж хүргэх. Мэдээлэл сурталчилгааны ажлын гол зорилтот бүлэг нь гэр хорооллын иргэд бөгөөд эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнээр зуухаа солих, гэр болон байшин сууцаа дулаалах аян, хөтөлбөрийг сурталчлан таниулах явдал юм.

Байгууллагын дотоод хэвлэл мэдээллийн хяналт хийх тогтолцоог бий болгох, үр дүнтэй харилцаа холбоо, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны багцыг (мэдээлэл, арга хэрэгсэл, платформ, суваг) ашиглах чадварыг сайжруулахын тулд ТХН-ийн багт дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

### **Хүлээлгэн өгөх зүйлс**

- УБЦА НСТ болон өмнөх төслийн олон нийтийн мэдээлэл сурталчилгааны холбогдох мэдээлэл дээр тулгуурлан ТХН-ийн агаарын бохирдлын эсрэг үр дүнтэй олон нийттэй харилцах мэдээлэл сурталчилгааны стратеги
- Мэдээлэл харилцааны технологийг ашиглан Зөвлөх багийн дангаараа болон бусад хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран боловсруулсан мэдээлэл харилцааны цогц арга хэрэгслүүд, платформ болон сувгууд
- Мэдээлэл харилцааны баяжуулсан арга хэрэгслүүд болон бүтээгдэхүүнүүд: брошюр, хэвлэлийн мэдээ, сайн түүх, ярилцлага, видео

сурталчилгаа болон Засгийн газрын агентлагуудын гаргасан бодлогын баримт бичиг, тойм судалгааны эмхэтгэлүүд.

- Утга агуулгын уялдаа холбоотой, хэвлэл мэдээллийн төрөл бүрийн арга хэрэгсэл, бүтээгдэхүүн, платформ, медиа сувгуудыг ашиглан системтэйгээр боловсруулж, түгээсэн теле цувралууд, хэвлэн нийтэлсэн бүтээгдэхүүнүүд болон зохион байгуулсан олон нийттэй харилцах арга хэмжээнүүд
- Хэвлэл мэдээллийн хяналтын систем

### Гэрээний үр дүнг тооцох

| <i>Хүлээлгэн өгөх зүйлс</i>   | <i>Төлбөрийн хуваарь</i>   | <i>Товлосон хугацаа, тайлбар</i>                                      |
|---|----------------------------|---|
| Эхлэлийн тайлан: Төслийн оролцогч талуудын зураглалыг шинэчлэх, УБ хотын агаарын бохирдолд гүйцэтгэж байгаа тэдгээрийн үүрэг, оролцоонд дүн шинжилгээ хийх  | Гэрээний үнийн дүнгийн 10% | Гэрээ байгуулснаас хойш 4 долоо хоногийн дотор                        |
| Явцын тайлан 1<br>Зөвлөх баг нь агаарын бохирдлын эсрэг авч хэрэгжүүлэх олон нийтийн мэдээлэл сурталчилгааны шинэчлэгдсэн стратеги, эхний жилийн төлөвлөгөө (мэдээлэл харилцааны хэрэгслүүд болон багц бүтээгдэхүүнүүд.<br>Үүнд: брошур, постер, олон нийтрүү чиглэсэн сурталчилгаа, зорилтот бүлэгт хүргэх мэдээлэл сурталчилгаа, платформ, мэдээлэл түгээх сувгууд). ТХН-р баталгаажуулж, хүлээлгэн өгнө. | Гэрээний үнийн дүнгийн 30% | Эхлэлийн тайланг ТХН-д хүлээлгэн өгсөнөөс хойш 6 долоо хоногийн дотор |
| Явцын тайлан 2<br>Эхний жилийн гүйцэтгэлийн тайлан, олон нийтийн мэдээлэл сурталчилгааны ажлын алдаа болон сургамж дээр үндэслэн дараагийн  | Гэрээний үнийн дүнгийн 30% | 2021 оны 3 дугаар сарын сүүлээр                                       |

|  |                               |                                     |
|--|-------------------------------|-------------------------------------|
| жилүүдэд авч хэрэгжүүлэх<br>PR-ийн төлөвлөгөө  |                               |                                     |
| Эцсийн тайлан<br>Олон нийтийн мэдээлэл<br>сурталчилгааны үйл<br>ажиллагаануудын дүгнэлт,<br>шинжилгээ, агаарын<br>бохирдлыг бууруулахад<br>оруулсан үр нөлөө, гол үр дүн | Гэрээний үнийн<br>дүнгийн 30% | 2021 оны 12 дугаар сарын<br>сүүлээр |

### **Хангамж, тоног төхөөрөмж**

Энэхүү ажлыг олон төрлийн ур чадвар, мэргэшил бүхий зөвлөхүүдээс бүрдсэн мэргэжлийн баг хийж гүйцэтгэнэ. Зөвлөх баг нь өөрийн тоног төхөөрөмж, интернет, оффисын байр, үйл ажиллагааны зардал, хэлмэрчлэл, баримт бичгийн орчуулга, логистикийн хангамж болон даалгаврыг гүйцэтгэхэд шаардагдах бүхий л зардлыг хариуцна.

### **Тайлагналт**

Зөвлөх баг нь ТХН-ийн зохицуулагчид ажлаа тайлагнана. Зөвлөх баг нь ТХН болон олон нийттэй харилцах ажилтантай хамтран ажиллана. Зөвлөх нь олон нийтийн мэдээлэл сурталчилгааны ажлыг явуулахдаа Эрчим хүчний яамны, Нийслэлийн агаарын болон Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны гэх зэрэг байгууллагуудын олон нийттэй харилцах ижил зорилго бүхий багтай хамтран ажиллаж, үйл ажиллагаагаа нягт уялдуулна.

### **Үргэлжлэх хугацаа**

Энэхүү даалгаврын нийт хугацаа 14 сар байх бөгөөд тооцоолсон хүн/ сар нь 21 хүн/ сар байна. 2020 оны халаалтын улиралд 12 хүн/ сар шаардагдана. Энэхүү даалгаврыг 2020 оны 9-р сарын эхээр эхлүүлэхээр төлөвлөж байна.

Эхний жилийн хөтөлбөр дууссаны дараа зөвлөхийн ажлын чанар, үр дүнг үнэлэх ба гүйцэтгэлийн үнэлгээнээс хамаарч зөвлөх үйлчилгээний хугацааг сунгах боломжтой.

### **Тавигдах шаардлага**

#### **Зөвлөх компани /ТББ-д тавигдах шалгуур үзүүлэлт**

- Ажлын цар хүрээ, хэмжээ, чиглэлийн хувьд ижил төстэй PR, сурталчилгааны 2 ажлыг сүүлийн 3 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн туршлагатай байх;

- Гэр хорооллын иргэд эсвэл агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр төсөл хөтөлбөр, байгууллагуудтай хамтран олон нийтэд чиглэсэн кампанит ажлыг зохион байгуулж байсан туршлагатай бол давуу тал болно.

#### Хүний нөөцөд тавигдах шалгуур үзүүлэлт

Мэргэшсэн боловсон хүчний тоо нь багийн ахлагчийг оруулаад 3-аас багагүй байна. Зөвлөх багийн гишүүд нь олон улсын байгууллага, төсөл хөтөлбөр, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран олон нийтийн мэдээлэл сурталчилгааны олон талт кампанит ажлыг зохион байгуулж байсан туршлагатай, ажлын арга барил, ур чадвар бүхий баг байх шаардлагатай.

#### Багийн ахлагчид тавигдах ерөнхий шаардлага:

- Сэтгүүл зүй, олон нийтийн харилцаа, мэдээлэл харилцааны чиглэлээр магистрын зэрэгтэй
- Олон нийтийн мэдээлэл сурталчилгаа, харилцаа холбооны чиглэлээр 7 жилийн ажлын туршлагатай байх
- Сүүлийн 3 жилийн хугацаанд Засгийн газрын болон олон улсын олон нийтрүү чиглэсэн төсөл хөтөлбөрийг удирдсан, хэрэгжүүлсэн, хяналт үнэлгээ хийсэн байх
- Англи болон Монгол хэл дээр тайлан бичих болон зохион байгуулах өндөр ур чадвартай байх
- Харилцаа холбооны олон төрлийн хэрэгсэл, платформ, сувгуудыг ашигладаг байх

#### Зах зээлийн судалгаа, харилцааны мэргэжилтэнд тавигдах ерөнхий шаардлага

Сэтгүүл зүй болон олон нийтийн харилцааны чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, зах зээлийн судалгаа, шинжилгээний чиглэлээр 5-аас доошгүй жил ажиллаж байсан туршлагатай.

- Гэр хорооллын айл өрх, агаарын бохирдлын эсрэг ажилладаг оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, тэдгээрт зориулсан мэдээлэл сурталчилгаа, харилцааны оновчтой арга барилыг боловсруулж, хэрэгжүүлэх ур чадвартай
- Олон нийт мэдээлэл сурталчилгааны үр дүнтэй стратеги, төлөвлөгөө боловсруулж байсан туршлага, ур чадвартай

#### Хэвлэл мэдээллийн ажилтанд тавигдах ерөнхий шаардлага

Сэтгүүл зүй болон олон нийтийн харилцааны чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай, хэвлэл мэдээллийн эх бэлтгэх ялангуяа агаар, орчны бохирдлын чиглэлээр мэдээ, мэдээлэл бэлтгэж байсан туршлагатай бол давуу тал болно

- Нийгмийн бүлгүүдтэй ажиллах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн харилцааны сувгуудаар дамжуулан арга хэмжээ зохион байгуулах, мэдээллийн сан байгуулах, мэдээлэл сурталчилгааны тогтвортой байдлыг хангах
- Төрөл бүрийн сонин сэтгүүл, өдөр тутмын мэдээллийн хэрэгслүүдээр нийтлэл, мэдээлэл бичиж байсан 3 жилийн туршлагатай байх
- Сургалт зохион байгуулах чадвартай бол давуу тал болно